



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН
ИХ СУРГУУЛЬ



КПУ
KYUNGPOOK NATIONAL UNIVERSITY

САНАМЖ БИЧИГ

Олон улсын тэргүүлэх их сургуулийн
тогтвортой хөгжлийг
дэмжих тухай

2024 он

МУБИС - КУИС

Олон улсын, тэргүүлэх их сургуулийн тогтвортой хөгжлийг дэмжих тухай САНАМЖ БИЧИГ

Монгол Улсын Боловсролын их сургууль (цаашид "МУБИС" гэх) болон БНСУ-ын Кёонбүг Үндэсний Их Сургууль, Солонгосын "Ургамал-Био Нэгдлийн Хөгжлийн Хүрээлэн" (цаашид "УБНХХ" гэх) хооронд тогтвортой хөгжлийн чиглэлээр олон улсын, тэргүүлэх их сургуулийг дэмжих санамж бичигт гарын үсэг зурав.

1 дүгээр зүйл (Зорилго) Энэхүү санамж бичгийн зорилго нь тогтвортой хөгжлийн төлөөх олон улсын тэргүүлэх их сургуулийг дэмжих зорилгоор "MNUE" болон "УБНХХ" хооронд харилцаа тогтоож, хувь нэмэр оруулахад оршино.

2 дугаар зүйл (Хамрах хүрээ) 1 дүгээр зүйлийн зорилгод хүрэхийн тулд талууд дор дурдсан хэлбэрээр хамтран ажиллана.Үүнд:

1. Цахим технологид суурилсан байгалийн ухааны хичээлийн хөтөлбөрийг хамтран боловсруулж, хэрэгжүүлэх
2. Оюутны авьяас чадварыг хөгжүүлэх солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлэх
3. Байгалийн ухааны тулгамдсан асуудлыг шийдвэрлэх талаар олон улсын хамтарсан судалгаа хийх
4. Байгалийн ухааны боловсролын талаарх сүүлийн үеийн судалгааны мэдээлэл, эрдэм шинжилгээний солилцоог дэмжих,
5. Тогтвортой хөгжлийн хүрээлэнгийн ха хөгжүүлэх

3 дугаар зүйл (Эрдэм шинжилгээ инновац) Эрдэм шинжилгээ инновацын ололт амжилтыг оюуны өмчийн байгууллагад бүртгүүлж болох бөгөөд эзэмших хувийг "УБНХХ" болон "МУБИС"-ийн оруулсан хувь нэмрийн хэмжээгээр тогтооно. Үүний зэрэгцээ, үндэсний Эрдэм шинжилгээ инновацын төслийн үр дүн нь холбогдох хууль, журамд нийцсэн байна.

4 дүгээр зүйл (Нууцлал) Талууд энэхүү санамж бичигтэй холбоотой бизнес эрхлэх явцад олж мэдсэн мэдээллээ нөгөө талын зөвшөөрөлгүйгээр гадагш задруулах, гуравдагч этгээдэд дамжуулахыг хориглоно. Энэхүү мэдээлэл нь санамж бичгийн хүчинтэй хугацаа дууссаны дараа ч нууцлалтай хэвээр байна.

байна.

5 дугаар зүйл (Олон нийттэй харилцах) Талууд төслийн үр дүнг олон нийтэд сурталчлахдаа нөгөө талын зөвшөөрөлтэйгөөр хамтарсан хоёр байгууллагын нэрээр зарлана.

6 дугаар зүйл (Санамж бичгийн тайлбар) Энэхүү санамж бичгийг тайлбарлах талаар талуудын хооронд гарсан аливаа санал зөрөлдөөн буюу гэрээнд заагаагүй зүйлд холбогдох хууль тогтоомж, практикт нийцүүлэн харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

7 дугаар зүйл (Нэмэлт нөхцөл) Энэхүү санамж бичиг нь талуудын итгэмжлэгдсэн төлөөлөгчид гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох бөгөөд 2 (хоёр) жилийн хугацаанд хүчинтэй байна. Энэхүү санамж бичгийг талууд бичгээр болон харилцан тохиролцох хүртэл хоёр жилээр автоматаар сунгаж болно.

Талууд энэхүү санамж бичгийн заалтуудыг үнэнчээр биелүүлж ажиллана. Санамж бичиг 2 хувь байх бөгөөд гарын үсэг зурж баталгаажуулснаар хувь тус бүрийг талууд хадгална.

2024 оны 11 дүгээр сарын 04 өдөр



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН
ИХ СУРГУУЛЬ

Монгол Улсын Боловсролын их сургууль
Бага Тойруу-14, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо Улаанбаатар-14191

Монгол Улс

Ж.Батбаатар
Ректор

9037702 4x9021051159



КНУ
KYUNGPOOK NATIONAL UNIVERSITY

"Солонгосын Ургамал-Био нэгдлийн хөгжлийн
хүрээлэн", Кёонбүг Үндэсний их сургууль
80 Даехак-ро, Бүк-гү, Даегү 41566, БНСУ

Үй Вүүк Хванг
Хүрээлэнгийн захирал